

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

2024.12.03

	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	2023 он	2024 он
№	Соёл, урлагийн салбар		
1.	Соёл, урлагийн байгууллага	22	22
2.	Мэргэжилтэй боловсон хүчний хангалт	88%	85%
3.	Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч	365	276
4.	Угийн бичиг хөтлөлт	58 өрх	132 өрх

1. СОЁЛ, УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ХАНГАЛТ

Соёл, урлагийн байгууллагын мэргэжлийн боловсон хүчний хангалт 85%-тай байна. (Мэргэжлийн боловсон хүчинд: бакалавр, сертификат, богино хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдыг оруулан тооцов)

2. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН ТОО:

2023 оны жилийн эцсийн тайлангаар аймгийн хэмжээнд 283 өвлөн уламжлагч бүртгэлтэй байна. 2023 онд 10 өвлөн уламжлагч нас барсан байна. Мөн 23 өвлөн уламжлагч шинээр бүртгэн баримтжуулсан. Өвлөн уламжлагчдыг Соёлын биет бус өвийн ай саваар авч үзвэл дараах байдалтай байна.

№	Соёлын биет бус өвийн ай сав	2022	2023	2024	Тайлбар
1	Эх хэл аман уламжлал, илэрхийллүүд- 21	28	21	26	2023 онд 10 өвлөн уламжлагч нас барсан байна. Мөн 23 өвлөн уламжлагч шинээр бүртгэн баримтжуулсан.
2	Ардын язгуур урлаг-97	129	97	99	
3	Үндэсний уламжлалт зан үйл, ёслол, баяр наадам-40	65	40	35	
4	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл-3	5	3	5	
5	Уламжлалт арга ухаан	40	27	29	
6	Мал маллах арга ухаан	4	1	2	
7	Уламжлалт гар урлал	94	87	88	
Нийт		365	276	283	

3. УГИЙН БИЧИГ ХӨТЛӨЛТ:

“Монголчуудын угийн бичгийн академи”-ийн Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтнийг “Угийн бичиг хөтлөлтийн арга зүй” сэдэвт сургалтад 2024 оны 04 дүгээр сард хамруулсан.

Сумдын Соёлын төвийн 19 нь номын санчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд аймгийн Нийтийн номын санд зохион байгуулсан бөгөөд тус сургалтад угийн бичиг хөтөлж хэвших ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдвээр хичээл орж, гарын авлагаар хангав.

Эрдэнэбулган сумын угийн бичиг хөтөлдөг 25 өрхийн төлөөллийн туршлага солилцох уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр аймгийн Нийтийн номын санд зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрх 2023 онд 99 байсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 33 өрх шинээр хөтөлж эхэлсэн байна. Аймгийн Засаг даргын 2025 - 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн "Соёл урлагийг дэмжих хөтөлбөр" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд угийн бичиг хөтлөх өрх, иргэнийг нэмэгдүүлэх, урамшуулах, сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулахаар тусган ажиллаж байна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН

ДАРГА

Д.АВАРЗАД

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТСҮХ